

ХАРЬЦУУЛСАН ФИЛОСОФИ, ТҮҮНИЙ ОНЦЛОГ

Д. Оюунгэрэл - ХААИС-ийн багш, МУИС –ийн докторант.

Түлхүүр үг. Харьцуулсан философи, философийн харьцуулсан судалгаа, харьцуулах арга

Харьцуулсан философийн үүсэл. Харьцуулсан философи нь Өрнийн ба Дорнын философийн уламжлал, ойлголт, ухагдахуун, сургаал, номлол, үзэл баримтлалуудыг өөр өөр түвшинд харьцуулан судалдаг философийн нэгэн бие даасан салбар юм. Харьцуулсан философи (comparative philosophy) нь орчин үед философийн бие даасан олон тооны урсгал чиглэл дотор шинэ тутам үүсэж буй харьцангуй залуу салбар ухаан юм. Энэ нь XVIII зууны эцэст Өрнө - Дорнын философи сэтгэлгээг харьцуулан судалдаг философийн нэгэн салбар болон үүсч хөгжсөн түүхтэй.

Харьцуулсан философи нь харьцангуй залуу салбар ухаан гэж тооцогддог ч түүний үүсэл нь эртний улбаатай юм. Анх эртний Грекчүүд зарим улс орны аж байдал, соёлыг танин мэдэхийг оролдож байсан үеэс эхлэлтэй хэмээн тооцдог байна. Анхны судалгааг Аристотель 2000 гаруй жилийн өмнө Грекийн хот улсуудын эдийн засгийн байгуулал, нийгмийн бүтэц, хүмүүс хоорондын ёс суртахууны харилцааны онцлог зэргүүдийг харьцуулан судлаж байсан түүхтэй ажээ.

Мөн философийн харьцуулсан судалгаа нь Өрнийн философи сэтгэлгээний уламжлалд философийн системүүдийг жишиж харьцуулсан судалгааны бүтээлүүдээс эхлэлтэй хэмээн үзэж болно. Энэ төрлийн судалгааны анхны бүтээлийн нэг нь Германы философич В.Гегелийн “Фихте, Шеллинг нарын философийн системийн ялгаатай талууд” хэмээх зохиол юм. Гегель энэхүү бүтээлдээ Фихтегийн субъектив идеализмийг Шеллингийн натурфилософитой харьцуулан судалж, Фихте нь субъектын бие даасан байдалд илүү ач холбогдол өгч байсан бол, Шеллинг нь субъектын идэвхит байдлыг үгүйсгэсэн бөгөөд аль аль нь өрөөсгөл үзэл болохыг илрүүлж, мөн тэдгээрийн философийн нийтлэг тал нь субъект ба объектын харилцааны асуудлыг тайлбарласан явдал болохыг тодорхойлжээ. Улмаар тэрхүү харьцуулсан судалгааныхаа үр дүнд Гегель “бодит байдал нь субъект ба объектын нэгдэл” хэмээн дүгнэжээ.

В.Гегелийн дээрх зохиол гарснаас хойш гурван жилийн дараа 1804 онд Францын философич Ж.И.Дежерандо “Хүн төрөлхтний мэдлэгийн зарчмыг

үндэслэн философийн түүхийн системийг харьцуулах нь” хэмээх гурван боть зохиол бичжээ. Цаашид философийн харьцуулсан судалгаа нь өргөжин тэлж, дорнын соёлыг европ төвт үзлийн үүднээс судлах болжээ. XVIII зуунд Яков Брукер “Шүүмжлэлт философийн түүх” гэдэг зохиолдоо алс дорнодын ард түмний оюуны амьдрал, философи сэтгэлгээний асуудалд ихээхэн анхаарлаа хандуулан харьцуулсан судалгааг хийсэн байдаг. XIX зуунаас эхлээд Виндишманы бүтээлүүд гарсанаар Европоос бусад орны сэтгэлгээний ололт, амжилт харьцуулсан философийн түүхэнд зохих байр сууриа олсон. Гэхдээ энэ үед харьцуулсан судалгаа хөгжлийнхөө эхэн үедээ буюу Дорно дахины соёл, сэтгэлгээний талаарх мэдээ, материалуудыг хуримтлуулах шатандаа байлаа.

Гэвч харьцуулсан философи нь XX зуунд л философийн мэдлэгийн бүрэлдэхүүн бие даасан чиглэл болон хөгжиж иржээ. Үүний нэг жишээ нь, 1939 онд Америкийн философич Ч.Мур, С.Нортроп, Ж.Конжер ба Дорнын философич Такакусу Зюнзиро, Чэнь Юньзи нарын санаачлагчид Хонолулу арал дээр дорно - өрнийн философичдын анхны бага хурлыг зохиож, Брахман ба Дао, буддын тогтсон таалал ба субстанцийн тухай Спинозагийн сургаалыг харьцуулан хэлэлцэж байсан байна. Эдүгээ энэхүү Хонолулугийн бага хурал улам өргөжиж, олон орны судлаачид оролцож, харьцуулсан философийн хэлэлцэх асуудал нь өргөжин нэмэгдсээр байгаа ажээ.

Харьцуулсан философийг бие даасан салбар болгон хөгжүүлэх үйл хэрэгт Францын энэтхэг судлаач, философич Поль Массон – Урсель тодорхой хувь нэмрийг оруулжээ. Түүний үзлээр, философийн онол, сургаалууд нь “мөнхийн асуудлыг судалж байснаараа нийтлэг ба харин тэрхүү асуудлыг тайлбарлаж байсан аргаараа ялгаатай бөгөөд судалгааны объектуудыг дотоод уялдаа холбоотой, нэгдсэн нэг систем болгон судлах нь чухал юм. Түүнийг харьцуулсан философийн үндсэн хөтөлбөрийг боловсруулсан гэж зарим судлаачид үздэг. Поль Массон – Урсель тухайн үеийн философийн харьцуулсан судалгааны дутагдлыг буюу харьцуулсан судалгаа нь зөвхөн ойлголт, үзэгдлийн нийтлэг дээр үндэслэгдэн явагдаж, улмаар мухардмал байдалд орж буйг шүүмжилсэн ба энэ нь тухайн үедээ нэлээд дэвшилттэй санаа байж үнэлэгдэж байсан байна. Энэхүү дутагдлыг даван туулахын тулд П.Массон – Урсель философийн системүүдийн нийтлэгийг үүргийн шалгуураар тогтоохыг санал болгожээ.

Харьцуулсан философид тодорхой судалгаа хийж хувь нэмэр оруулсан хүний нэг бол У.Джонс бөгөөд тэрээр эртний Өрнийн ба Дорнын философийн

системүүдийг харьцуулсан судалгаа хийсэн байдаг. Тухайлбал, эртний Энэтхэг ба Грекийн философийн системийн нийтлэг болон ялгаатай шинжүүдийг олохыг зорьж, Ньяя ба Перипатек, Вайшешика ба Ионийн сургууль, Санкхья ба Пифагор, Йога ба Стоикууд, Миманса, Ведантыг үндэслэгчид болох Джаймини, Вьяса нарын философийг Сократ, Платон нарын философитой тус тус харьцуулан судалжээ. Санкхья чиглэл болон Пифагорын сургаал нь тооны утгыг эрэлхийлж байснаараа, Ньяя чиглэлийг үндэслэгч Готама, Аристотель нар нь логикийн системийг боловсруулснаараа, Вайшешика чиглэлийг үндэслэгч Канада, Фалес нар нь байгалийн философийг хөгжүүлснээрээ, Йогийн чиглэлийг үндэслэгч Патанджали ба Зенон нар хүний зөв амьдрахуйн зарчмыг боловсруулсанаараа тус тус нийтлэг байна хэмээн үзжээ. XX зууны дорно дахины философид Энэтхэгийн философич Ражу, Хятадын философич Фэн Ю лань, Ху Ши, Японы философич Нишида Китаро нарын олон философичид харьцуулсан философийн чиглэлээр сонирхолтой судалгаанууд хийсэн буй.

Философийн харьцуулсан судалгаанд “нийтлэг” ба “ялгаатай” талуудыг харьцуулах явдал үндсэн зарчим нь болдог. Соёл, шинжлэх ухаан, хүний оршихуйн юмс үзэгдлийг бүхэлд нь авч үзээд, тэдгээрийн нийтлэг ба ялгаатай талуудыг харьцуулан судалсанаар тухайн үзэгдлүүдийн дотоод шүтэлцээг илрүүлэн, илүү гүн гүнзгий, бүрэн гүйцэд ойлголтыг авах боломжтой. Гагцхүү үүнд л философийн харьцуулсан судалгааны давуу тал оршино. Философийн харьцуулсан судалгааны гол ач холбогдол нь юмс үзэгдлийг харьцуулсаны үндсэн дээр тухайн үзэгдлүүдийн дотоод мөн чанар, шүтэлцээг олох гол хэрэгсэл болдогт оршино.

Нөгөө талаас, XX зуунд философийн түүхэнд байгаагүй эрчимтэйгээр янз бүрийн үзэл баримтлалуудын нэгдэх үйл явц өрнөж, тэдгээрийн зорилго нь нийгэм – соёлын нөхцөл, тухайн цаг үедээ захирагддаггүй философийн онолыг бий болгоход оршино. Учир нь харьцуулсан философийн судалгааны гол зорилго нь философийн системүүдийг дураараа, механик байдлаар нэгтгэх биш, харин өөр хоорондоо ялгаатай, дахин давтагдашгүй, өвөрмөц шинжээ хадгалсан боловч мөн чанарыг нийтлэг үндэслэлтэй, ерөнхий хуваагчтай системүүдийн нэгдлийг бий болгох явдал билээ.

• • • **Харьцуулсан философийн судлах зүйл ба зорилго.** • Орчин үед • • • • •
харьцуулсан философи нь Өрнө - Дорно гэсэн дихотоми буюу эсрэгцэл болсон асуудлыг судалдаг. Сүүлийн 20-30-аад жилд Өрнийн соёл иргэншлийн сөрөг талуудад шүүмжлэлтэй хандах, түүний хөгжлийн цаашдын чиг хандлагыг

тодорхойлох зэрэг тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд харьцуулсан философийн судалгаа чухал байр суурьтай болж ирсэн. Харьцуулсан философийн зорилго нь нийт хүн төрөлхтний философийг (бүх сэдвийг) хамруулах явдал бөгөөд энэ нь түүнийг бусад философиос ялгаж өгч байдаг ажээ. Гэхдээ энд нэг зүйлийг тэмдэглэхэд харьцуулсан философи бол “сэдвийн бөөгнөрөл” биш, харин философийн янз бүрийн урсгал чиглэлүүдийн үзэл баримтлалуудыг судлаж, нийтлэг санал дүгнэлтүүдийг томъёолох явдал болно.

Харьцуулсан философид харьцуулсан судалгаа хийхдээ эхлээд судалгааны зорилго, зорилтоо тодорхойлж, судалгааны объектоо сонгон авч дараа нь харьцуулалт хийх арга зүйн баримтлалаа боловсруулах ёстой гэдэг. Гэхдээ харьцуулсан философид асуудал нь зорилгоосоо хамаараад нэлээд ярвигтай тулгардаг. Учир нь харьцуулсан философийн зорилго нь нийт хүн төрөлхтний философийг (бүх сэдвийг) хамруулах явдал. Энэ нь харьцуулсан философид өөрийн гэсэн дагнасан судлах зүйл, үндсэн асуудал, өөрөөр хэлбэл, судалгааны бодитой салбар “байдаггүй” гэдгийг харуулж байна. Учир нь харьцуулсан философи нь философид хамаарах бүгдийг судлах болдог. Гэхдээ харьцуулсан судалгаа нь бүх сэдвийг хамарсан, тэдгээрийг зөвхөн зэрэгцүүлж жиших хэлбэр төдий үйл ажиллагаа бус юм. Харьцуулсан философи нь тэр тэгсэн, энэ ингэсэн гэх өнгөц хандлагыг өөрчилж, асуудал шийдвэрлэх, тайлбарлах, цаашлаад харьцуулсан судалгааны нарийн арга хандлагуудыг хөгжүүлэхэд өнөөгийн харьцуулсан судалгааны мөн чанар оршино. Ийм учир харьцуулалт хийхэд тодорхой онцлогууд харагдана. Тухайлбал, харьцуулалт бол хийсвэрлэл бөгөөд тодорхой үзэл санаа, үзэл баримтлалуудыг яг зэрэгцүүлж харьцуулахад бэрхшээлтэй. Учир нь философийн асуудал бүхэн давтагдашгүй өөрийн гэсэн онцлогтой. Мөн харьцуулалт хийхээс өмнө ухагдахуун ойлголтуудыг тогтоож, утга холбогдлыг нарийн тодорхойлох ёстой.

Харьцуулсан философид хамгийн гол арга нь харьцуулалтын арга юм. Тийм учраас энэхүү философийг судлах зүйлээр нь бус, аргаар нь нэрлэсэн байж болох талтай. Харьцуулсан философийн арга нь дэлхийн философийн үзэл баримтлалуудын тусгаар, өвөрмөц, бусдаасаа ялгаатай онцлогийг нь хадгалан, бусад философийн үзэл баримтлалтайхэрхэн холбогдох, бусдад өөрийгөө нээх боломжийн үндсийг тавьдгаараа онцлогтой. Ер нь харьцуулалтын арга нь бүхий л шинжлэх ухаанд тодорхой хэмжээгээр хэрэглэгдэж ирсэн учраас түүний үүслийг шинжлэх ухааны үүсэлтэй холбон ярьж болох бөгөөд энэ арга нь XIX зуунд шинжлэх ухааны түгээмэл арга зүй болон хөгжжээ.

Харьцуулалтын арга бол танин мэдэхүйн ерөнхий арга юм. Хүмүүс өдөр тутмын амьдралд юмс үзэгдэл, баримт, төсөөлөл, үйл явцыг харьцуулж, тэдгээрийн хоорондын ерөнхий бас ялгаатай талуудыг олж тогтоохыг оролдож байдаг. Нэг үгээр харьцуулалт бол ертөнцийг танин мэдэх, чиг баримжаагаа олоход хүнд туслах чадвар юм. Иймд харьцуулалт нь танин мэдэхүйн аргын хувьд судлаж байгаа үзэгдлүүдийн ерөнхий хийгээд өвөрмөц онцлогийг илрүүлж гаргах арга юм.

Орчин үеийн аливаа судалгаанд харьцуулах арга өргөн хэрэглэгддэг. Харьцуулах арга нь соёлын үзэгдлүүдийг, философийн соёлыг, шинжлэх ухааны парадигм, философийн үзэл баримтлалуудыг судлахад өргөн хэрэглэгддэг. Харьцуулалтын арга нь судлаж байгаа үзэгдлүүдийн нийтлэг шинж, онцлогийг илрүүлэх, аливаа үр ашигтай хэлбэр буюу үзлийг хэрэгжүүлэх хамгийн оновчтой арга замыг олж тогтоох зорилгоор судлаж байгаа юмс үзэгдлүүдийг хооронд нь харьцуулан жиших бололцоо олгодог. Харьцуулалтын аргыг хэрэглэсэнээр судлаачдын мэдлэгийн цар хүрээ өргөжих, бусад мэдлэгийн үр ашгийг хэрэглэх боломж бий болно хэмээн үздэг. Харьцуулалт бол зарчмын хувьд хүний сэтгэхүйн зайлшгүй бүрэлдэхүүн хэсэг мөн. Иймээс харьцуулалт бол хүмүүнлэгийн болон байгалийн аливаа шинжлэх ухааны танин мэдэхүйн арга зүйн цөм гэж хэлж болох юм.

Философийн түүхийн өнгөрсөн, өнөөг судлахын зэрэгцээ, түүний туршлагыг өөр хооронд жишиж байж, түүний тухай илүү өргөн бас гүнзгий төсөөлөл мэдлэгтэй болно. Иймээс харьцуулсан шинжилгээ судалгаа нь бидний мэдлэгийг улам тэлж өгнө. Философийн харьцуулсан судалгаа нь философийн сэтгэлгээний түүхэнд ийнхүү чухал үүрэгтэй. Өнөөдөр харьцуулсан философийн үүрэг ач холбогдол улам бүр өсөж байна. Гагцхүү харьцуулж байж философийн системийг бүрэн дүүрэн ойлгож, дасал болсон мэдлэгийн тойрог дотроо эргэлддэгээс гарч чадна. Харьцуулалт бол онол бүтээх, бас онолыг шалгах боломж өгдөг гэж судлаачид үзжээ. Энэ утгаараа харьцуулсан философи нь өрнө дорнын философийн түүхэн туршлага, орчин үеийн философийн сургаал, тэдгээрийн хөгжлийг нухацтай судлах боломж нөхцлийг олгоно. Энэ нөхцөл боломжийг ашиглахын тулд юуны өмнө харьцуулсан шинжилгээний орчин үеийн ямар арга, техник, арга зүй байх вэ? гэдэг нь маш чухал. Бүхнийг харьцуулсан арга, арга зүй, техникээр хязгаарлаж болохгүй ч үүнгүйгээр судалгаа шинжилгээ цааш явах аргагүй учраас харьцуулсан философийн судалгааны үүрэг ач холбогдол өсөн нэмэгдэж байна.

Ийнхүү философийн ийм төрлийн судалгааны салбар үүсэн багагүй хугацаа өнгөрч энэ салбар нь орчин үеийн философийн төдийгүй соёлын нэг салшгүй хэсэг болж чаджээ. Харьцуулалт бол философийг судлах арга зүйн цөм мөн. Харьцуулсан философи нь философийн янз бүрийн үзэл, онолыг харьцуулан судалж, улмаар тэдгээрийн үр дүнд өөрсдөө шинэ ойлголт, шинэ үзэл боловсруулах боломжтой болдог байна.

Ашигласан ном зохиол

- История современной зарубежной философии: компаративистский подход. Т.1-2. 3-е издание. СПб., 1998.
- Сравнительная философия. М., 2000
- Raju P.T. Introduction to Comparative Philosophy, Lincoln, 1962